БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/123/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых<br>Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан........9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан........12
3. Аудитын тайлан........14
3.1 Ерөнхий зүйл ........14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........15
3.4 Материаллаг байдал ........15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........18
3.8 Аудитын гол асуудал ........18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........19
4. Аудитын илрүүлэлт ........19
4.1 Залруулсан алдаа........19
4.2 Төлбөрийн акт........19
Байхгүй ........19
4.3 Албан шаардлага ........19
4.4 Зөвлөмж ........19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.07 № 21
танай ____________-ны № ____________-т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Н.ОТГОНТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

2-12 EBS dugnelt

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

2-12 EBS dugnelt

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **80022080.65** | **83790080.87** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 200000.00 | 0.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 200000.00 | 0.00 |
| **3121** | **Төгрөг** | 200000.00 | 0.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 200000.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | 7714563.00 | 450000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 7264563.00 | 0.00 |
| **335** | **Бусад авлага** | 450000.00 | 450000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 450000.00 | 450000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 72107517.65 | 83340080.87 |
| **351** | **Түүхий эд материал** | 22995525.00 | 23015525.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22612525.00 | 22612525.00 |
| 35130 | Эм боох материал | 383000.00 | 403000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 49111992.65 | 60324555.87 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1764574.00 | 805960.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2298240.00 | 2038300.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1803350.00 | 1421350.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 43245828.65 | 56058945.87 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4989826433.27** | **4844001858.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4989826433.27 | 4844001858.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4749826433.27 | 4604001858.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4824136749.00 | 4824136749.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -360884383.34 | -490828272.50 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2500000.00 | 2500000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2500000.00 | -2500000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 306632248.88 | 337562848.88 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -249288155.92 | -268419574.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 259049719.85 | 262087719.85 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -153441689.17 | -181291201.42 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 55025945.00 | 55025945.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -44772337.76 | -48908529.50 |
| 39217 | Ном | 113368336.73 | 114636173.31 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 240000000.00 | 240000000.00 |
| 39301 | Програм хангамж | 1782150.00 | 1782150.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1782150.00 | -1782150.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 240000000.00 | 240000000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5069848513.92** | **4927791938.91** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **92195601.00** | **161997560.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 92195601.00 | 161997560.00 |
| **413** | **Өглөг** | 92195601.00 | 161997560.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 92195601.00 | 161997560.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 92195601.00 | 161997560.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4977652912.92** | **4765794378.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4977652912.92 | 4765794378.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 708383260.45 | 708383260.45 |
| 51101 | Өмч: - төрийн | 708383260.45 | 708383260.45 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3168403690.75 | 2956545156.74 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3168403690.75 | 3168403690.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -211858534.01 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1100865961.72 | 1100865961.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5069848513.92** | **4927791938.91** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,712,535,730.50** | **2,770,743,106.92** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,180,981.00** | **8,061,652.22** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,180,981.00 | 8,061,652.22 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,180,981.00 | 8,061,652.22 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,180,981.00 | 8,061,652.22 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,710,354,749.50** | **2,762,681,454.70** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,406,371,249.50 | 2,421,566,023.70 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 47,873,049.50 | 28,766,323.70 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,358,498,200.00 | 2,392,799,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 850,000.00 | 32,077,731.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150,000.00 | 31,470,731.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 700,000.00 | 607,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 303,133,500.00 | 309,037,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 303,133,500.00 | 309,037,700.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,871,572,594.30** | **2,966,378,593.81** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,871,572,594.30** | **2,966,378,593.81** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,772,967,564.30 | 2,858,518,712.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,979,583,755.00 | 2,003,842,413.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,655,725,325.00 | 1,738,132,906.00 |
| 210102 | Нэмэгдэл | 149,706,000.00 | 144,735,996.00 |
| 210104 | Урамшуулал | 174,152,430.00 | 120,973,511.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 248,543,154.00 | 261,431,092.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 169,371,334.00 | 181,903,414.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,910,593.00 | 19,995,142.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,917,637.00 | 15,969,232.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,941,854.00 | 3,960,301.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,401,736.00 | 39,603,003.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 308,354,012.00 | 377,339,659.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,434,138.00 | 3,585,533.00 |
| 210302 | Түлш, халаалт | 298,388,494.00 | 365,699,126.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,531,380.00 | 8,055,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,370,236.00 | 9,533,838.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,162,750.00 | 1,992,181.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,590,000.00 | 877,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,585,586.00 | 1,829,917.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 491,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,500,000.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,531,900.00 | 3,943,140.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,451,200.00 | 2,211,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,159,200.00 | 52,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,292,000.00 | 2,159,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 537,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 537,000.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 177,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 177,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 812,500.00 | 1,623,450.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 112,500.00 | 1,023,450.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 218,315,707.30 | 201,359,460.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,129,946.00 | 20,298,449.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 210,185,761.30 | 181,061,011.81 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 98,605,030.00 | 107,859,881.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52,910,100.00 | 94,522,800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52,910,100.00 | 94,522,800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45,694,930.00 | 13,337,081.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45,694,930.00 | 13,337,081.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(159,036,863.80)** | **(195,635,486.89)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 16,223,047.12 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 16,223,047.12 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (16,223,047.12) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(159,036,863.80)** | **(211,858,534.01)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | | 0.00 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **708,383,260.45** | **1,100,865,961.72** | **3,168,403,690.75** | 4,977,652,912.92 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **708,383,260.45** | **1,100,865,961.72** | **3,168,403,690.75** | 4,977,652,912.92 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **708,383,260.45** | **1,100,865,961.72** | **3,168,403,690.75** | 4,977,652,912.92 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | -211,858,534.01 | -211,858,534.01 |
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **708,383,260.45** | **1,100,865,961.72** | **2,956,545,156.74** | 4,765,794,378.91 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2662481700.00** | **2733915131.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0.00** | **0.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2662481700.00** | **2733915131.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2358498200.00 | 2392799700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2358498200.00 | 2392799700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 850000.00 | 32077731.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 150000.00 | 31470731.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 700000.00 | 607000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 303133500.00 | 309037700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 303133500.00 | 309037700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2660504000.00** | **2711421971.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2660504000.00** | **2711421971.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2561898970.00** | **2603562090.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1958572282.00 | 1990342400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1643344979.00 | 1734547400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 149706000.00 | 134080000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 165521303.00 | 121715000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 264391802.00 | 267666542.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 185424003.00 | 188052942.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19525499.00 | 19903400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15851300.00 | 15922700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3962800.00 | 3980600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39628200.00 | 39806900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 303783500.00 | 307537700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4781700.00 | 4781700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 290946800.00 | 294701000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 8055000.00 | 8055000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15876386.00 | 7458417.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3095900.00 | 1086900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1640000.00 | 877600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2358000.00 | 1829917.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 246386.00 | 491000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1500000.00 | 400000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7036100.00 | 2773000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6754500.00 | 2779500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 422100.00 | 450300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6332400.00 | 2329200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 0.00 | 1500000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 1500000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 0.00 | 177700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 177700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1262900.00 | 2152700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 562900.00 | 1552700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 700000.00 | 600000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11257600.00 | 23947131.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11257600.00 | 23947131.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **98605030.00** | **107859881.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 52910100.00 | 94522800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52910100.00 | 94522800.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 45694930.00 | 13337081.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 45694930.00 | 13337081.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1977700.00** | **22493160.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **0.00** | **0.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1777700.00** | **22693160.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1777700.00** | **22693160.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1777700.00 | 22693160.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1777700.00 | 22693160.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1777700.00** | **-22693160.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 200000.00 | -200000.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 200000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 200000.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2701837400.00 | 2688535319.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2701837400.00 | 2688535319.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2595284900.00 | 2594012519.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1990342400.00 | 1990342400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1734547400.00 | 1734547400.00 |
| 210102 | Нэмэгдэл | 134080000.00 | 134080000.00 |
| 210104 | Урамшуулал | 121715000.00 | 121715000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 268696100.00 | 267666542.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 189082500.00 | 188052942.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19903400.00 | 19903400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15922700.00 | 15922700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3980600.00 | 3980600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39806900.00 | 39806900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 307537700.00 | 307537700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4781700.00 | 4781700.00 |
| 210302 | Түлш, халаалт | 294701000.00 | 294701000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8055000.00 | 8055000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8745800.00 | 8502977.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1086900.00 | 1086900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 577600.00 | 577600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2072400.00 | 1829917.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2235900.00 | 2235560.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 0.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2773000.00 | 2773000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2779500.00 | 2779500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 450300.00 | 450300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2329200.00 | 2329200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1500000.00 | 1500000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1500000.00 | 1500000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 177700.00 | 177700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 177700.00 | 177700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2152700.00 | 2152700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1552700.00 | 1552700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600000.00 | 600000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13353000.00 | 13353000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13353000.00 | 13353000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 106552500.00 | 94522800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 106552500.00 | 94522800.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 106552500.00 | 94522800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2701837400.00 | 2688535319.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2392799700.00 | 2379497619.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2392799700.00 | 2379497619.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 309037700.00 | 309037700.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 309037700.00 | 309037700.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 139 | 146 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 109 | 114 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29 | 31 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1933 | 2145 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1933 | 2145 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1933 | 2145 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **139** | **146** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 110 | 115 |
| 650006 | Соёл урлагийн салбарын тєрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1 | 2 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 27 | 28 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **32,277,731.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,242,731.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 13,242,731.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 700,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 |

| | | |
|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,542,731.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,542,731.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **35,000.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 35,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **19,000,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 19,000,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 19,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 32,077,731.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 32,077,731.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 31,470,731.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 607,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 200,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор В.Хуандых гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус сургууль нь 2021 оны хичээлийн жилд "Суралцагчийн сурлагын хоцрогдлыг нөхөж, бие даан сурах үйлийг дэмжихэд бүх талын оролцоог ханган, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" зорилготой ажиллаж, дараах үндсэн 9 дэд зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1.Сургуулийн сурлагын хоцрогдол нөхөх арилгах төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх.
2. Багш ээлжит хичээлийн бэлтгэлийг сургалтын хэлбэрээс үл хамааран чанартай бэлтгэж, үр дүнтэй хэрэгжүүлэх.
3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын үр дүнг ахиулах.
4. Даалгаварт суурилсан арга зүйг боловсруулж сурлагын чанарт ахиц гаргах.
5. Багш ажилчид, сурагчдыг стресээс сэргийлэх, айдас түгшүүр, сэтгэл зовинолгүй ажиллах, суралцахад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бүрдүүлэх.
6. Хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжэн оролцоог хангаж, сургууль завсардахаас сэргийлэн, эцэг эх олон нийттэй хамтран ажиллах.
7.”Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”-ын хүрээнд сургуулийн мэргэжлийн бүлгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх.
8. Монгол хэл, бичгийн чадварыг сайжруулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх.
9.Сурагчдыг тэгш хамруулан сургах үйлийг дэмжих, дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуульд 2021 онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй. Аймгийн Боловсролын газар, Мэргэжлийн хяналтын газраас шалгалт хийсэн байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжтэй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна. Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,871.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 28.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142.0 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 200.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 7,714.6 | 450.00 | -7,264. 6 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 72,107.5 | 83,340.1 | 11,232.6 |
| Үндсэн хөрөнгө | 4,989,826.4 | 4,844,001.8 | -145,824.6 |
| **Нийт хөрөнгө** | **5,069,848.5** | **4,927,791.9** | **-142,056.6** |
| Өр төлбөр | 92,195.6 | 161,997. 6 | 69,801.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,977,652.9 | 4,765,794.4 | -211,858.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **5,069,848.5** | **4,927,791.9** | **-142,056.6** |

Мөнгөн хөрөнгө оны эхэнд 0.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, оны эцэст үлдэгдэлгүй байна. Оны эхний үлдэгдэл нь нэмэлт санхүүжилтийн харилцахын үлдэгдэл байна.

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 5.3 сая, хувь хүний орлогын албан татварын 2.0 сая, ажиллагсадаас авах 0.5 сая, нийт 7.7 сая төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 7,.3 сая төгрөгөөр бууруулж 0.5 сая төгрөгийн авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 83.3 сая төгрөг болж 11.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд үнэ төлбөргүй хандиваар 8.1 сая төгрөгийн бараа материал хүлээн авснаас шалтгаалж үлдэгдэл өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,844.0 сая төгрөг болж 145.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 22.6 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 28.8 сая буюу нийт 51.4 сая төгрөгөөр нэмэгдсэн ба 16.2 сая төгрөгийн номыг акталж, үндсэн хөрөнгөнд 181.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

Оны эхэнд халаалтын зардалд 92.2 сая төгрөгийн өглөгтэй байсан нь нэмэгдэж, оны эцэст 161.9 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,765.8 сая төгрөг болж 211.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -211,858.54 мянган төгрөг гарснаас шалтгаалжээ.

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,770.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 58.2 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй бараа материал авсан, тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас нэмэлт санхүүжилт авсантай холбоотой нэмэлт санхүүжилтийн орлого материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 94.8 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглахтай холбоотой тогтмол зардлаас түлш, халаалтын зардал, бусад урсгал шилжүүлэгээс төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардал буюу үдийн цайны зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2020 оны анх батлагдсан төсөв 2,384.5 сая төгрөг, тодотгосон төсөв 2,701.8 сая төгрөг байна.

Тодотгосон төсөв нь анх баталсан төсвөөс 317.4 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Үүнд: цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 341.7 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 46.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, хангамж бараа материалын зардлыг 2.7 сая, нормативт зардлыг 0.8 сая, томилолтын зардлыг 1.1 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалыг 66.0 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж тодотгосон байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 387.9 сая төгрөгөөр дутуу суулгасан, нэмэгдэл, урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь тайлант онд 2,701.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 2,688.5 сая төгрөгийг зарцуулж, төсвийн гүйцэтгэл нь нийт дүнгээр 3.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарчээ.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төсвийг нийт дүнгээр 13.3 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хэмнэлттэй гарсан зардлууд нь: НДШ-ийн зардлыг 1.1 сая, шуудан, холбоо, интернэтийн төлбөрийг 0.2 сая, үдийн цайны зардлыг 12.0 сая буюу нийт 13.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Үдийн цайны зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлж 13.3 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 31.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 0.6 сая, нийт 32.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн харилцахын дансны эхний үлдэгдэл 0.2 сая төгрөг байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 0.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 12.5 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 19.0 сая, нийт 32.2 сая төгрөгийг зарцуулж, 0.03 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль тайлант онд “Эрчим” ХХК-д халаалтын зардалд батлагдсан 294.7 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч оны эцэст 162.0 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 69.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь халаалтын зардлын төсвийг сургуулийн төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь 2021 онд нийт 6,211.7 сая төгрөгийн 19 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6,211.7 сая төгрөгийн 117 мэдээллийг ил тод байршуулсан 2 мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь 2021 онд 2,701.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд төсвөөс зарцуулагдаагүй 7.3 сая төгрөгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоонд шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага, нэмэлт төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 0.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн байна. Дээрхи зөрчлүүдийг арилгаж 7.3 сая мянган төгрөгийн авлагыг барагдуулж, нэмэлт санхүүжилтийн тайлант оны зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж, өмнөх оны алдаа, зөрчлийг давтан гаргаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй

### 4.3 Албан шаардлага

Байхгүй

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | |